



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 9/199

Цагаан-Уул сум

Г Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын орлогчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, багийн Засаг даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийг цаг тухай бүрт нь чанартай зохион байгуулж, гүйцэтгэж ажиллахыг Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангуйж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дагын албан үүргийг тур орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.





ХОРОШИЙ АДМИНИСТРАТИВНЫЙ
УЧИЛИЩЕ - САНКТ-ПЕТЕРБУРГ
ЗАКАТ ТВАРЬ

Санкт-Петербургский государственный бюджетный
учебно-исследовательский институт
по подготовке специалистов в области
внутренней политики и правоохранительной

академии
бюджет

нини
тот

A/200

области, в том числе в сельской местности
и селах, поселках, деревнях, селениях,

посёлках, селенях, селах, деревнях, селениях,

посёлках, селенях, селах, деревнях, селениях,

Муха бывшая
шагах тухаеъ



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 9/201

Цагаан-Уул сум

Г Эрх бүхий албан тушаалтан
томулх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3, Авлигын эсрэг хуулийн 11 дугаар зүйлийн 11.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.1.5, Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Шагдарын Эрдэнэцэцгийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс Эрх бүхий албан тушаалтнаар /ЭБАТ/ томилсугай.

2. Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ын нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцон олгохыг зөвшөөрсүгэй.

3. Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт түүнийг буртгэх, хадгалах, хянах, тайлагнах, холбогдох нийтийн олон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг чандлан хадгалах, хамгаалахыг (Ш.Эрдэнэцэцг) /ЭБАТ/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүйн мэргэжилтэн (Б.Ичинхорлоо)-д даалгасугай.

5. Уг захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн A/77 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



/Zahiramj 2024/



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 8/202

Цагаан-Уул сум

Г Хяналт тавьж, хүлээн авах комисс
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Нийтийн эзэмшлийн талбай тохижуулах ажилд хяналт тавьж, хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ахлагч: Ч.Эрдэнэчuluун (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: А.Хишигбаяр (Төрийн сангийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Н.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Зураг төсвийн дагуу дээрх ажилд хяналт тавьж, хүлээн авч тэмдэглэл хөтлөж, акт үйлдэж ажиллахыг хяналт тавьж, хүлээн авах комисс (Ч.Эрдэнэчuluун)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.





ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 7/203

Цагаан-Уул сум

Г Сумын байгууллага, аж ахуйн нэгжийг
шилдгээр шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд сумынхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг хангахад манлайлан ажиллаж байгаа байгууллагыг шалгаруулж, шагнасугай.

- Төрийн өмчит байгууллагаар – “Галт дулаан” ХХК - өргөмжлөл, 500.000 (Таван зуун мянган) төгрөг
- Хувийн байгууллагаар – “Урьхан хангайн хишиг” ХХК - өргөмжлөл, 250.000 (Хоёр зуун тавин мянган) төгрөг

2. Нийт 750.000 (Долоон зуун тавин мянган) төгрөгийг орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг), нягтлан бодогч (Ч.Оюунчимэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүйн мэргэжилтэн (Б.Ичинхорлоо)-д даалгасугай.

